



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/674

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны XVII/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнээс ЭМТ-ийн шүдний тасгийн тоног төхөөрөмж (Сайхан сум) худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир)-т олгосугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулж, тайланг сар бүрийн 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир)-д үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

4. Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Д.Батцогт/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

